

БАТЛАВ.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

4295335 1922050017 ГСТ7344

“ЦАСНЫ БАЯР”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Монгол Улсын Ерөнхийлөгчийн өвлийн биеийн тамир, спортыг дэмжин хөгжүүлэх тухай 27 дугаар Зарлиг, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Биеийн тамир, спортын газрын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 08 тоот “Мөнгөн өвөл-2024” цасны баярыг зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд Соёл, урлагийн нийт ажилтнууд, уран бүтээлчид, ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний бие бялдрыг хөгжүүлэх, спортыг нэмэгдүүлэх, хамт олонч үзэл санааг нэгтгэхэд оршино.

Хоёр. Ерөнхий зохион байгуулагч

Дархан-Уул аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл

Гурав. Хугацаа, байршил:

2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 09:30 цагт, Дархан-Уул аймгийн Орхон сумын “Цагаан” нуурт

Дөрөв. Тэмцээнд оролцох байгууллага, баг

Соёл, урлагийн ажилтнууд, соёлын биет бус өвлөн уламжлагч, уран бүтээлчид зэрэг эрэгтэй, эмэгтэй тусдаа сугалаагаар бүрдсэн холимог баг бүрдэнэ. Баг тус бүр мэндчилгээ дэвшүүлнэ.

“Цасны баяр”-т оролцох байгууллагууд:

1. Соёл, урлагийн газар
2. Залуучууд театр
3. Аймгийн Музей
4. Төв номын сан
5. Хүүхдийн номын ордон
6. Орхон сумын Соёлын төв
7. Шарын гол сумын Соёлын төв
8. Хонгор сумын Соёлын төв
9. Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Дархан салбар
10. Нарыг хайрла “Хойд бүсийн гэрэл зурагчдын холбоо”
11. Дарханы Зураач урчуудын эвлэл
12. Дархан хотын Чөлөөт уран бүтээлчид

13. ЕБС, СӨБ дуу хөгжмийн багш нар
14. Бүжгийн холбоо
15. Монголын Зохиолчдын эвлэлийн Дархан салбар зөвлөл
16. Соёлын биет бус өвлөн уламжлагчид

Тав. Тэмцээний төрөл:

1. Даавуутай гар бөмбөг – 4 хүний бүрэлдэхүүнтэй.
2. Морин барилдаан - Эрэгтэй 1, эмэгтэй 1
3. Олс таталт - 8 хүний бүрэлдэхүүнтэй.
4. Мөсөн боулинг - 5 хүний бүрэлдэхүүнтэй
5. Чаргатай бухиа уралдаан – Эрэгтэй 1, эмэгтэй 1

Зургаа: Тэмцээн явуулах журам

- Нэгдсэн шалгаруулалтыг Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл шүүнэ.
- Цасны баярт оролцох байгууллагууд шагналын хураамж 50.000 төгрөг хураалгана. /Хаан банк: 5046203376 Х.Отгонбаяр 99849222/
- Тэмцээнийг сугалаанаас хамаарч тоглолтын хуваарийг гаргана.
- Багууд зохион байгуулалттай байх, сахилга бат, ёс зүйг баримтлан оролцоно.
- Нийлбэр оноогоор тэргүүлсэн эхний 5 багт Өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулна.

Долоо. Зохион байгуулалт

- Дэлгэрэнгүй мэдээллийг Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн тэргүүн Ц.Баттөмөр /99120435/, тэргүүлэгч Дарханы Зураач, урчуудын эвлэлийн тэргүүн Н.Хишигбаатар /95927444/, Соёл, урлагийн газрын мэргэжилтэн Б.Долгормаа /99393046/ нартай холбогдоно уу.
- Цасны баярт оролцогч байгууллагууд өдрийн хоол, халуун цай зэргийг тус тусдаа зохион байгуулалт хийнэ.
- Цасны баярт оролцогчдын мэдүүлгийг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл Соёл, урлагийн газрын мэргэжилтэн Б.Долгормаад doogii0209.b@gmail.com мэйл хаягаар хүлээн авна. /Утас:91914497, 99393046/

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН
ЗАЛУУЧУУЛЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ**